

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2023/114/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум  
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	12
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	16
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	16
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	16
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	17
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	17
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

## **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

№ 01/103  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ  
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.МЯГМАРЖАВ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 215,844.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 45,657.1 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 154,051.2 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

### Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын жилийн нийт төсвийн 57.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал эзэлж байна.

### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 5 зорилт 99 арга хэмжээг төлөвлөж 98.7 хувь хэрэгжүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>133,921,809.41</b>	<b>189,704,174.91</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>133,921,809.41</b>	<b>189,704,174.91</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>130,886,809.41</b>	<b>185,674,174.91</b>
35410	Бичиг хэргийн материал	1,864,270.00	3,554,488.00
35420	Аж ахуйн материал	22,837,524.41	61,570,551.91
35430	Сэлбэг хэрэгсэл	2,000,000.00	3,320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	7,000.00
35450	Барилгын засварын материал	10,583,550.00	5,624,600.00
35460	Хүнсний материал	165,300.00	10,000.00
35470	Бусад хангамжийн материал	93,436,165.00	111,587,535.00
35600	Мал амьтад	3,035,000.00	4,030,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>959,725,345.83</b>	<b>1,175,569,782.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>959,725,345.83</b>	<b>1,175,569,782.12</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>891,844,945.84</b>	<b>991,332,032.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	741,271,503.40	817,445,315.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	-233,977,855.36	-277,483,384.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,044,800.00	282,668,311.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-131,873,617.64	-156,758,541.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,398,687.00	257,236,191.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-82,958,896.31	-123,219,382.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,943,700.00	87,073,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,683,015.62	-36,180,286.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	184,440,078.40	244,190,078.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-92,760,438.03	-103,639,970.05
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>67,880,399.99</b>	<b>184,237,749.95</b>
39301	Програм хангамж	3,185,000.00	3,185,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,670,000.01	-2,466,250.05
39303	Бусад биет бус хөрөнгө	66,365,400.00	183,519,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,093,647,155.24</b>	<b>1,365,273,957.03</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,093,647,155.24</b>	<b>1,365,273,957.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,093,647,155.24</b>	<b>1,365,273,957.03</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	703,146,831.77	703,146,831.77
51101	Өмч: - төрийн	703,146,831.77	703,146,831.77
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>156,351,697.25</b>	<b>427,725,888.77</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	156,351,697.25	156,099,086.98
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	271,626,801.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,148,626.22	234,401,236.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,093,647,155.24</b>	<b>1,365,273,957.03</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>855,921,348.40</b>	<b>1,208,511,845.40</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>195,265,036.40</b>	<b>370,277,025.40</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>195,265,036.40</b>	<b>370,277,025.40</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,265,036.40	370,277,025.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,102,940.00	5,629,900.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>660,656,312.00</b>	<b>838,234,820.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>33,133,312.00</b>	<b>17,138,320.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,829,500.00	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,200,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,917,442.00	5,268,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,186,370.00	5,149,920.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>627,523,000.00</b>	<b>821,096,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	627,523,000.00	821,096,500.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>827,887,677.87</b>	<b>936,885,043.61</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>812,087,677.97</b>	<b>809,808,843.61</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>694,321,321.38</b>	<b>660,437,459.68</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>265,635,180.00</b>	<b>276,711,640.46</b>
210101	Үндсэн цалин	217,643,872.70	213,019,630.46
210102	Нэмэгдэл	47,213,333.00	45,099,136.00
210104	Урамшуулал	777,974.00	18,592,814.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,560,005.89</b>	<b>34,651,476.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,290,677.89	23,840,043.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,702,939.00	2,804,709.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,138,830.00	2,193,368.00
210204	Ажилгүйдлийн даатгал	491,389.00	528,487.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,936,170.00	5,284,869.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,377,505.22</b>	<b>60,380,495.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,676,804.22	4,478,203.07
210302	Түлш, халаалт	53,836,701.00	54,998,192.00
210303	Цэвэр, бохир ус	864,000.00	904,100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>76,321,516.43</b>	<b>64,601,868.94</b>
210401	Бичиг хэрэг	4,232,950.00	6,295,874.00
210402	Тээвэр, шатахуун	22,402,221.00	32,157,465.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,035,440.00	3,800,701.00
210404	Ном, хэвлэл	199,320.00	248,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,200,000.00	13,463,662.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,658,935.43	8,040,666.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	595,500.00

210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	9,592,650.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	510,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,193,600.00	19,261,250.00
210604	Урсгал засвар	11,193,600.00	19,261,250.00
2107	Томилолт, зочны зардал	1,859,900.00	2,892,200.00
210702	Дотоод албан томилолт	1,859,900.00	2,892,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,458,161.00	21,714,448.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,642,067.00	19,764,605.60
210803	Даатгалын үйлчилгээ	432,000.00	448,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,994.00	291,994.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	89,769.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	676,500.00	726,000.00
210807	Газрын төлбөр	415,600.00	394,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	232,915,452.84	179,714,030.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,989,630.50	34,599,214.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	2,240,875.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	143,545,822.54	142,873,991.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,766,356.59	149,371,383.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,420,900.00	33,874,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	31,374,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,671,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	749,900.00	2,499,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,345,456.59	115,497,333.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,345,456.59	115,497,333.93
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,799,999.90	127,076,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,799,999.90	127,076,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,033,670.33	271,626,801.79
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	296,238.52	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	296,238.52	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-296,238.52	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,737,432.01	271,626,801.79

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	692,027,602.00	846,986,420.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,781,090.00	7,051,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,781,090.00	7,051,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,781,090.00	7,051,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,781,090.00	7,051,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	669,246,512.00	839,934,820.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,723,512.00	18,638,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,829,500.00	1,720,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,200,000.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,917,442.00	5,268,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,776,570.00	6,849,920.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>627,523,000.00</b>	<b>821,096,500.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	627,523,000.00	821,096,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>638,640,002.00</b>	<b>651,116,960.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>638,640,002.00</b>	<b>651,116,960.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>519,233,555.41</b>	<b>501,165,576.07</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>265,710,143.82</b>	<b>276,809,327.00</b>
210101	Үндсэн цалин	217,718,836.52	213,117,317.00
210102	Нэмэгдэл	47,213,303.30	45,099,196.00
210104	Урамшуулал	777,974.00	18,592,814.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,461,642.07</b>	<b>34,553,739.46</b>
210201	Тэтгэврийн даатгал	24,074,084.04	24,057,018.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,709,933.14	2,664,806.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,159,889.34	2,067,639.86
210204	Ажилгүйдлийн даатгал	508,016.06	532,881.47
210205	Эрүүл мэндийн даатгал	5,009,719.49	5,231,423.83
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59,377,505.22</b>	<b>60,380,495.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,676,804.22	4,478,203.07
210302	Түлш, халаалт	53,836,701.00	54,998,192.00
210303	Цэвэр, бохир ус	864,000.00	904,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>39,799,498.00</b>	<b>54,296,130.54</b>
210401	Бичиг хэрэг	3,462,570.00	3,458,200.00
210402	Тээвэр, шатахуун	22,402,168.00	32,841,626.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,035,440.00	3,908,701.00
210404	Ном, хэвлэл	199,320.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,200,000.00	10,643,132.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	444,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>00.00</b>	<b>510,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	510,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,320,190.00</b>	<b>15,524,500.00</b>
210602	Тавилга	00.00	140,000.00
210604	Урсгал засвар	9,320,190.00	15,384,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,859,900.00</b>	<b>2,892,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,859,900.00	2,892,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>42,737,176.00</b>	<b>25,339,007.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	40,921,032.30	27,440,004.00
210803	Даатгалын үйлчилгээ	432,000.00	449,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,934.00	291,934.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	89,769.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	676,500.00	726,000.00

210807	Газрын төлбөр	415,600.00	394,080.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,967,500.00</b>	<b>26,809,177.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,667,700.00	24,514,873.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,299,800.00	2,294,304.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>119,406,446.59</b>	<b>149,951,383.93</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,060,990.00</b>	<b>34,454,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	2,612,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	31,374,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,671,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,389,990.00	467,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>79,345,456.59</b>	<b>115,497,383.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,345,456.59	115,497,383.93
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>53,387,600.00</b>	<b>195,869,460.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>53,387,600.00</b>	<b>195,869,460.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>53,387,600.00</b>	<b>195,869,460.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>53,387,600.00</b>	<b>195,869,460.00</b>
223001	Бусад хөрөнгө	24,050,000.00	154,013,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,337,600.00	41,856,460.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-53,387,600.00</b>	<b>-195,869,460.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	255,386,575.43	107,376,316.03	1,065,909,723.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	703,146,831.77	255,386,575.43	128,614,265.24	1,087,147,672.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,737,432.01	27,737,432.01
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,148,626.22	156,351,697.25	1,093,647,155.24

D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,148,626.22	156,351,697.25	1,093,647,155.24
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-252,610.27	-252,610.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	703,146,831.77	234,148,626.22	156,099,086.98	1,093,394,544.97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	252,610.27	00.00	252,610.27
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	271,626,801.79	271,626,801.79
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	703,146,831.77	234,401,236.49	427,725,888.77	1,365,273,957.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	568,019,200.0	523,517,716.1	44,501,483.9	92.2
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	568,019,200.0	523,517,716.1	44,501,483.9	92.2
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	533,044,700.0	489,063,716.1	43,980,983.9	91.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	283,591,400.0	276,809,327.0	6,782,073.0	97.6
210101	Үндсэн цалин	232,207,400.0	213,117,317.0	19,090,083.0	91.8
210102	Нэмэгдэл	51,384,000.0	45,099,196.0	6,284,804.0	87.8
210104	Урамшуулал	00.0	18,592,814.0	-18,592,814.0	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,448,600.0	34,553,789.5	894,810.5	97.5
210201	Тэтгэврийн даатгал	24,608,500.0	24,057,018.1	551,481.9	97.8
210202	Тэтгэмжийн даатгал	2,710,100.0	2,664,806.2	45,293.8	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,168,000.0	2,067,659.9	100,340.1	95.4
210204	Ажилгүйдлийн даатгал	542,000.0	532,881.5	9,118.5	98.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,420,000.0	5,231,423.8	188,576.2	96.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,100,000.0	60,380,495.1	719,504.9	98.8
210301	Гэрэл, цахилгаан	5,000,000.0	4,478,203.1	521,796.9	89.6
210302	Түлш, халаалт	55,000,000.0	54,998,192.0	1,808.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.0	904,100.0	195,900.0	82.2
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	49,649,200.0	47,829,680.5	1,819,519.5	96.3
210401	Бичиг хэрэг	2,000,000.0	1,991,700.0	8,300.0	99.6
210402	Тээвэр, шатахуун	28,254,400.0	27,841,626.6	412,773.4	98.5

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100,000.0	3,908,701.0	191,299.0	95.3
210404	Ном, хэвлэл	200,000.0	200,000.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,594,800.0	13,443,152.9	1,151,647.1	92.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.0	444,500.0	55,500.0	88.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>614,000.0</b>	<b>510,000.0</b>	<b>104,000.0</b>	<b>83.1</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	614,000.0	510,000.0	104,000.0	83.1
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,841,000.0</b>	<b>16,710,500.0</b>	<b>2,130,500.0</b>	<b>88.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
210602	Тавилга	2,000,000.0	1,975,000.0	25,000.0	98.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.0	00.0	1,500,000.0	00.0
210604	Урсгал засвар	13,341,000.0	12,735,500.0	605,500.0	95.5
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,000,000.0</b>	<b>2,892,200.0</b>	<b>1,107,800.0</b>	<b>72.3</b>
210702	Дотоод албан томилолт	4,000,000.0	2,892,200.0	1,107,800.0	72.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>42,496,900.0</b>	<b>26,402,967.0</b>	<b>16,093,933.0</b>	<b>62.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,566,900.0	24,453,124.0	15,113,776.0	61.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,000.0	00.0	580,000.0	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.0	448,000.0	2,000.0	99.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	310,000.0	291,994.0	18,006.0	94.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	170,000.0	89,769.0	80,231.0	52.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.0	726,000.0	274,000.0	72.6
210807	Газрын төлбөр	420,000.0	394,080.0	25,920.0	93.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>37,303,600.0</b>	<b>22,974,757.0</b>	<b>14,328,843.0</b>	<b>61.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,303,600.0	21,480,453.0	12,823,147.0	62.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	1,494,304.0	1,505,696.0	49.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,974,500.0</b>	<b>34,454,000.0</b>	<b>520,500.0</b>	<b>98.5</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,974,500.0</b>	<b>34,454,000.0</b>	<b>520,500.0</b>	<b>98.5</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,600,000.0	2,612,000.0	988,000.0	72.6

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,374,500.0	31,374,500.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.0	467,500.0	-467,500.0	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>258,077,300.0</b>	<b>189,133,000.0</b>	<b>68,944,300.0</b>	<b>73.3</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>258,077,300.0</b>	<b>189,133,000.0</b>	<b>68,944,300.0</b>	<b>73.3</b>
223001	Бусад хөрөнгө	258,077,300.0	189,133,000.0	68,944,300.0	73.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>826,096,500.0</b>	<b>717,796,686.1</b>	<b>108,299,813.9</b>	<b>86.9</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>497,154,700.0</b>	<b>710,745,086.1</b>	<b>-213,590,386.1</b>	<b>143.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	497,154,700.0	710,745,086.1	-213,590,386.1	143.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>328,941,800.0</b>	<b>7,051,600.0</b>	<b>321,890,200.0</b>	<b>02.1</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.0	7,051,600.0	-2,051,600.0	141.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	323,941,800.00	00.00	323,941,800.00	00.0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>00.00</b>	<b>5,145,970.00</b>	<b>-5,145,970.00</b>	
620001	Удирдах ажилтан	28.00	26.00	02.00	92.9
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	12.00	02.00	85.7
620004	Гэрээт ажилтан	05.00	05.00	00.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,838,320.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>18,838,320.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>18,838,320.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,466,500.00</b>
210401	Бичиг хэрэг	1,466,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,649,000.00</b>
210604	Урсгал засвар	2,649,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,888,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,888,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,334,420.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,334,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>18,838,320.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>18,838,320.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,720,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,268,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,849,920.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Цагаан-Уул сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

ЗДТГ-ын эрхэм зорилго: Иргэдэд ойр, уян хатан, идэвхтэй, санаачилгатай, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн байхад оршино. Эрхэм зорилгын хүрээнд дараах зарчмыг баримтлан ажиллаж байна.

- Амласан амлалт, хүлээсэн үүрэг, удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийг заавал биелүүлдэг, хариуцлага хүлээдэг, цаг хугацааг баримталдаг байх.
- Бүхий л үйл ажиллагаандаа гол ч шударга ,мэргэжлийн гагцхүү баримтад тулгуурласан нам ч бус, аливаа үзэл суртлаас ангид байх
- Ажил нь үнэн бодитой, алдаа мадаггүй, цаг үеэ олсон ашиг тустай байх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт эрсэн байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний

байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Цагаан-Уул сумын ЗДТГ-ын даргын тушаалаар 5 орон тоотой дотоод хяналтын нэгж томилон ажиллуулж байна. Дотоод хяналтын нэгж нь жилийн эхэнд төлөвлөгөө боловсруулан удирдлагаар батлуулж, төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг гүйцэтгэж, үр дүнг танилцуулан ажилладаг байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Цагаан-уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 271,626.8 мянган төгрөгөөр буюу 24 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	0	0
Бараа материал	133,921.8	189,704.1	55,782.3

Үндсэн хөрөнгө	959,725.3	1,175,569.8	215,844.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,093,647.1</b>	<b>1,365,273.9</b>	<b>271,626.8</b>
Өр төлбөр	-	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,093,647.1	1,365,273.9	271,626.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,093,647.1</b>	<b>1,365,273.9</b>	<b>271,626.8</b>

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 215,844.5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 200,722.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 775,705.2 мянган төгрөг, нийт зарлагыг 775,705.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 74,311.9 мянган төгрөгөөр бууруулж 701,393.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 134,446.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 321,832.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 496,304.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 17,702.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 710,745.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлогоос 7,051.6 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 712,650.7 мянган төгрөг буюу 85.2 хувьтай байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	357,395.6	344,444.7	12,950.9	96.3%
2		80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	692,54.2	68,790.1	464.1	99%
3		80112-Нийтлэг үйлчилгээ	41,124.4	37,259.4	3,865.0	90%
4		80205-Мэдээлэл сурталчилгаа	2,000.0	562.0	1,438.0	28%
5		80305-Биеийн тамир тэмцээн уралдааны зардал	3,000.0	2,335.8	664.2	77%
6		80309-Уналга цуглралт бэлтгэл сургуулилт	500.0	500.0	0.0	100%

7		80802-Ажил олгогчоос олгох урамшуулал тэтгэмж,	3,600.0	3,079.5	520.5	85%
8		80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	31,374.5	31,374.5	0	100%
9		81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	15,000.0	5,959.1	9,040.9	39%
10		81103-Эрсдлийн сангийн нөөц хөрөнгө	5,000.0	4,257.6	742.4	85%
11		82210-Хотын доторхи золбин нохой муур устгах	3,000.0	2,720.7	279.3	90%
12		82801-Улсын их баяр наадам	2,203.6	1,063.8	1,139.8	48%
13	70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	80918-Бусад	258,077.3	189,133.0	68,944.3	73%
14	70801-МАН-г хөгжүүлэх	82503-Эрчимжсэн МАН-г хөгжүүлэх	7,959.3	3,675.8	4,283.5	46%
15	71413-Байгал орчин хамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	26,607.6	17,494.5	9,113.1	65%
Нийт дүн			826,096.5	712,650.5	113,446.0	86%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 18,838.3 мянган төгрөг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 827,887.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 16,557.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэвлэл захиалгын төлбөр 31.2 мянган төгрөг төлсөн байна. Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" 12.1.3."хэвлэлийн захиалгын төлбөр" заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төлбөрийн акт тогтоосон.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2014 оны 68 дугаар тогтоол болон 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар эдийн засгийн ангилал зөрчсөн 424.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	424.0	1	424.0	100%
Нийт дүн	1	424.0	1	424.0	100%

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.2 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 31.2 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн	1	31.2	1	31.2	-	-	-	-
Дүн	1	31.2	1	31.2				

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

17



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

№ 14/АЭЭТЭ/109/ХӨА-2023/014/11А  
ЦТА - ТНЗ

Мөрөн сум

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын төсвөөс хэвлэл захиалгын төлбөрт 31,200 (Гучин нэгэн мянга хоёр зуун) төгрөг төлсөн байна.

Дээрх зөрчил нь "Төрийн хэмнэлтийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно" 12.1.3./хэвлэлийн захиалгын төлбөр/ заалтыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн

### ТОГТООХ нь:

- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын төсвөөс төлсөн 31,200 /Гучин нэгэн мянга хоёр зуун/ төгрөгийг ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмаржав, нягтлан бодогч Ч.Оюунчимэг нараас гаргуулж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мягмаржав, нягтлан бодогч Ч.Оюунчимэг нарт хариуцуулав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Т.ИЧИНХОРЛОО

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 303, тоот Утас:70384043